

БАТЛАВ
ТАМГЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БУНДХОРОЛ

Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
АВТО ЗАМЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАМ ГҮҮРНИЙ АЖИЛ, ӨРГӨТГӨЛ
ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
САНАЛЫН БАРИМТ БИЧИГ

/СОНГИНОХАЙРХАН, ЧИНГЭЛТЭЙ, СҮХБААТАР ДҮҮРЭГ/

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 11-САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: <i>Үндэсний аудитын газар 15160. Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр</i>
2	<p>Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:</p> <p><i>Шинжээч нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын Эрсдэлийн удирдлагын газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.</i></p> <p><i>Гүйцэтгэгч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.</i></p> <p><i>Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.</i></p>
3	Гүйцэтгэгчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: <i>“үгүй”</i>
4	Санал хүлээн авах хугацаанаас 1 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө. Хаяг: Үндэсний аудитын газрын Тамгын газар.
5	Саналыг <i>Монгол хэлээр</i> ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон гүйцэтгэгч, мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: <i>“үгүй”</i>
7	Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх хугацаа:
8	Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: <i>тухайн багцад хамаарах төсөвт өртөг</i>
9	Гүйцэтгэгчийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин: <i>Төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төслийн эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, ажлын гүйцэтгэлд мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргаж чадахуйц, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай байна.</i>
10	Гүйцэтгэгчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг <i>Монгол хэлээр</i> бэлтгэнэ.
11	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага. <i>Ажлын даалгаарыг хавсаргасан. ЛУАГ-АД/2024-37/</i>
12	Татвар: <i>Гүйцэтгэгч нь хууль, журмын дагуу татвар, төлбөр хураамжийг өөрөө хариуцна.</i>

	<i>Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан төлбөрийн хуваарийн дагуу цахим төлбөрийн баримтын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн үед төлбөрийг шилжүүлнэ.</i>
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1
14	Санал ирүүлэх хаяг: Цахимаар Үндэсний аудитын газар, Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Б.Бямбасүрэн. byambasurenb@audit.gov.mn. Гар утас: 99641235./
15	Саналыг <i>2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 15 цаг 30 минутаас өмнө</i> ирүүлсэн байна.
16	(а) Төсөвт өртөг нь 50 сая ба түүнээс дээш ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардана. (б) Гүйцэтгэлийн баталгааг зохих маягтын дагуу гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх бөгөөд гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас багагүй байна. Гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцооллыг хавсарган/

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

 (Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- *Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.*
- *Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.*

Баталгаажуулах

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.

I. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1.2 Нэр томъёоны тайлбар Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
 - (б) “Гүйцэтгэгч” гэж захиалагч, шалгагдагч этгээдтэй байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
 - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
 - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
 - (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
 - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
 - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
 - (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ. /Хэрэв байгаа бол/
 - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн аль нэгийг, харин “Талууд” гэж оролцогчдыг нь хэлнэ.
 - (з) “Нөхөн төлөх зардал” гэж Гүйцэтгэгчийн ажлын хөлснөөс бусад үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
 - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
 - (м) “Үйлчилгээ” гэж Ажлын даалгаварт тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
 - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 - (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.
- 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3 Гэрээнд ашиглах хэл Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.

- 1.4 Мэдэгдэл Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 Байршил Үйлчилгээг ажлын даалгаварт заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч Гэрээний дагуу захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 Татвар, хураамж Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 Авлигал болон залилан мэхлэх үйлдэл Захиалагчийг төлөөлөн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон сонгон шалгаруулалтад оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч Гүйцэтгэгч бүр сонгон шалгаруулалтад оролцох, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон оролцогч шинжээч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 Үйлчилгээг эхлэх Гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш талууд гэрээг дүгнэж дуусгавар болгоно.
- 2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.

- 2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл
- 2.5.3 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.
- 2.5.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Гүйцэтгэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 2.6 Гэрээ цуцлах
- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах
- Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй:
- (б) Гүйцэтгэгч (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа:
- (в) Гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалтад оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авлигал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа:
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон:
- (д) Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:
- 2.6.2 Шинжээчийн санаачилгаар гэрээг цуцлах
- Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй
- (а) Захиалагч нь ГЕН-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг Гүйцэтгэгчийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй:
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:

3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон

чанар	<p>үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.</p> <p>Гүйцэтгэгч нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн Гүйцэтгэгчийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.</p> <p>Төрийн аудитын болон шалгагдагч этгээд байгууллага, түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж ажиллах, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй шинжээч аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад нэгэн адил үйлчилнэ.</p>
3.2 Ашиг сонирхлын зөрчил	Гүйцэтгэгч нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.
3.3 Нууцлал	Гүйцэтгэгч, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа мэдээллийг аливаа этгээдэд дамжуулах, үйлчилгээний үр дүн, түүнд хамаарах аливаа баримт, тайлан мэдээг нийтэд нээлттэй болгох эрхгүй бөгөөд хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
3.4 Гүйцэтгэгчийн хариуцах даатгал	Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа	Гүйцэтгэгч нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд: <ul style="list-style-type: none"> (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх, (б) Гүйцэтгэх ажилд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах. (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
3.6 Тайлагнах хуваарь	Гүйцэтгэгч нь тайлан гаргах хуваарьт заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.
3.7 Шинжээчийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь	Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж Гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ.
3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт	Гүйцэтгэгч нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу

шалгалт болон Аудит хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт Гүйцэтгэгчийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарьт тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтад багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих
- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Гүйцэтгэгчийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.
 - (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
 - (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсэж болох ямар нэгэн нэмэлт зардлыг гүйцэтгэгч нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох Захиалагч нь ГТН-д заасан шинжээчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуульд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

6. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрийн хэмжээ нь ажлын даалгаварт тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д

тодорхойлно.
(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.

- | | |
|---------------------------------|--|
| 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр | ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг гаргаж захиалагчаас зөвшөөрөл авна. |
| 6.4 Төлбөр хийх нөхцөл. хуваарь | Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан Гүйцэтгэгчийн дансанд хийнэ.
ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой. |

7. ШУДАРГА БАЙДАЛ

- | | |
|--------------------|--|
| 7.1 Шударга байдал | Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биений эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна. |
|--------------------|--|

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- | | |
|-------------------------------------|--|
| 8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх | Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтад ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.
Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. |
| 8.2 Маргааныг шийдвэрлэх | Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй. |

9. БУСАД

- | | |
|---|--|
| 9.1 Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын эрх үүрэг | Энэхүү гэрээг захиалагч, гүйцэтгэгч, шалгагдагч этгээд гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд талууд холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. |
|---|--|

II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчилнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Авто замын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж дүрэм, журам болон стандарт.
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	<p><u>Захиалагч:</u> Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газар Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IY байр. Харилцах хүн: Аудитын менежер Н.Анхбаяр Утас: 323266 И-мэйл: info@audit.gov.mn</p> <p><u>Шалгагдагч этгээд:</u> Харилцах хүн: /нөхөх/ И-мэйл: /нөхөх/</p> <p><u>Гүйцэтгэгч:</u> Харилцах хүн: /нөхөх/ И-мэйл: /нөхөх/</p>
1.7	<p><u>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</u> Захиалагчийн: /нөхөх/ Шалгагдагч этгээдийн: /нөхөх/ Гүйцэтгэгчийн: /нөхөх/</p>
1.8	Гүйцэтгэгч нь хууль журмын дагуу татвар, төлбөр, хураамжийг өөрөө хариуцна.
{2.1}	Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: <i>Гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурсан өдрөөс.</i>
2.2	Үйлчилгээ эхлэх хугацаа: <i>Гэрээ байгуулсан өдрөөс гүйцэтгэгч ажлыг эхэлсэнд тооцно.</i>
2.3	Гэрээний дуусгавар болох хугацаа:
3.4	Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: Гэрээний туршид Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.
{3.5 (в)}	<p>Бусад үйл ажиллагаа:</p> <p>Захиалагч гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт хэрэгжүүлнэ.</p>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>Нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний үнэ байна. Гэрээний үнэд тохируулга хийж болохгүй.</i>

8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.
-----	---

.....
.....
..... ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар №

2024 оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас
регистрийн дугаартай (цаашид “гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны ...
сарын ...-ний өдөр энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав. Үүнд:

- 13. Үйлчилгээ**
- 13.1.** Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох дугаар “Ажлын даалгавар”-т заасны дагуу “.....” ажил үйлчилгээг (цаашид “ажил” гэх) гүйцэтгэх үүрэгтэй.
 - 13.2.** Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхдээ “Гүйцэтгэгчийн ажиллах хүчний жагсаалт”-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.
 - 13.3.** Гүйцэтгэгч нь ажлын даалгаврын хавсралт дахь “Тайлан (дүгнэлт) гаргах хуваарь”-т заасан хугацаанд тайлан (дүгнэлт) гаргаж захиалагчид ирүүлнэ.
 - 13.4.** Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээх бөгөөд сонгон шалгаруулалтад оролцсон баримт бичиг, ажлын даалгавар, ажиллах хүчний жагсаалт, гүйцэтгэгчийн тайлан гаргах хуваарь зэрэг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 14. Хугацаа**
- 14.1.** Гүйцэтгэгч нь ажлыг 2024 оны ... дугаар сарын ...-наас 2024 оны ... дугаар сарын ...-ний хооронд, эсхүл талуудын бичгээр харилцан тохиролцсон хугацаанд гүйцэтгэнэ.
- 15. Төлбөр**
- 15.1. Төлбөрийн дээд хэмжээ.**
Захиалагч нь гүйцэтгэгчид гүйцэтгэсэн ажлын төлбөрт төлөх дээд хэмжээ нь(.....) төгрөг болно. Энэ дүнд гүйцэтгэгчийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн гүйцэтгэгчид ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно.
 - 15.2. Төлбөрийн хуваарь.**
Төлбөрийг доорх хуваарийн дагуу хийнэ:
 - а) Гүйцэтгэгчийн гарын үсэг зурсан гэрээний хувийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: [төлбөрийн 30 хүртэл хувь];
 - б) Хүлээн зөвшөөрөхүйц явцын тайлан (дүгнэлт)-ийн төслийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: [төлбөрийн 30 хүртэл хувь];
 - в) Хүлээн зөвшөөрөхүйц эцсийн тайлан (дүгнэлт)-ийг захиалагч хүлээн авсны дараа төлөх дүн: [төлбөрийн 40 хүртэл хувь];

Нийт төлөх дүн: [төлбөрийн дүн, валютыг заах];

15.3. Төлбөрийн нөхцөл.

Төлбөрийг 4 дүгээр зүйлд заасан төлбөрийн нэхэмжлэхийн хувийг захиалагчийн төлөөлөгчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор [төгрөг]-өөр хийнэ.

3.4. Энэхүү гэрээний 3.2-ын б, в-д заасан тайлан (дүгнэлт) “Хангалттай” гэж үнэлэгдсэн тохиолдолд тухайн үе шатны ажлын төлбөрийг бүрэн, “Хангалтгүй”, “Сайжруулах шаардлагатай” гэж үнэлэгдсэн тохиолдолд гүйцэтгэлийн үнэлгээний хувийг үндэслэн төлбөрийг тооцож олгоно.

16. Удирдлага

16.1. Ажилд хяналт тавих эрх бүхий этгээд.

Захиалагч нь [албан тушаал, нэрийг бич]-ийг ажилд хяналт тавих эрх бүхий этгээдээр томилж байгаа бөгөөд энэхүү этгээд нь гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг зохицуулах, төлбөрийн нэхэмжлэх, тайлан болон бусад бичиг баримт, эд зүйлсийг хүлээн авч батлах үүргийг хүлээнэ.

16.2. Тайлан

Гүйцэтгэгч нь “Тайлан (дүгнэлт) гаргах хуваарь”-т заасан тайланг хуваарийн дагуу ирүүлэх бөгөөд энэ нь 3 дугаар зүйлийн дагуу төлбөр хийх үндэслэл болно.

17. Гүйцэтгэлийн чанар

17.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэгчийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол гүйцэтгэгч уг ажилтныг нэн даруй солино.

18. Нууцлал

18.1. Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай мэдээллийг, эсхүл захиалагчийн үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.

18.2. Бүрэн эцэслээгүй тайлан, дүгнэлтийг бусдад танилцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

18.3. Нууц мэдээллийг зохих зөвшөөрөлгүй задруулсан буюу ашигласан бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

19. Өмчлөл

19.1. Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэнэ.

20. Гүйцэтгэгч зарим нэг үйл ажиллагаанд оролцохгүй байх

20.1. Гүйцэтгэгч, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ ажил болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрч байна.

21. Даатгал, хариуцлага

21.1. Гүйцэтгэгч нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.

21.2. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн

энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

21.3. Захиалагч гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

22. Эрх шилжүүлэлт **22.1.** Гүйцэтгэгч нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.

23. Гэрээнд мөрдөх хууль ба хэл **23.1.** Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь *[Монгол]* хэл байна

24. Маргааныг шийдвэрлэх **24.1.** Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....
.....

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....
.....